



I-V/2021

Тархаасан: 2021 оны 6 дугаар сарын 14



Улсын хэмжээнд 2021 оны эхний 5 сард 30.0 мянган эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 1352 (4.3%)-оор буурсан байна. Амаржсан эхчүүдийн 22.7 мянга (75.5%) нь 6, түүнээс дээш удаа жирэмсний хяналтад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 525 (2.3%)-аар буурчээ. Нийт амаржсан эхчүүдийн 88 (0.3%) нь гэртээ төрсөн нь өмнөх оны мөн үеэс 22 (20.0%)-оор буурсан байна.


Хүснэгт 1. Амаржсан эх, төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

Үзүүлэлт	2018 I-V	2019 I-V	2020 I-V	2021 I-V	$\frac{2021 \text{ I-V}}{2020 \text{ I-V}}$
Амаржсан эх	31 574	31 748	31 362	30 010	95.7
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	23 549	23 828	23 179	22 654	97.7
Гэрийн төрөлт	118	102	110	88	80.0
Амьд төрсөн хүүхэд	31 786	31 974	31 593	30 240	95.7
1 цагийн дотор хөхөө амласан хүүхэд	30 777	30 864	30 505	28 916	94.8
Төрөлхийн гажигтай төрсөн	211	270	272	249	91.5
2500 граммаас доош жинтэй төрсөн	1 448	1 373	1 484	1 174	79.1
Амьгүй төрсөн хүүхэд	172	182	172	148	86.0
Амьгүй төрөлтийн түвшин (1000 нийт төрөлтөд ногдох)	5	6	5	5	-

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Улсын хэмжээнд 2021 оны 5 дугаар сард 6233 эх амаржиж, өмнөх сараас 75 (1.2%)-аар нэмэгджээ. Амаржсан эхчүүдийн 4810 (77.2%) нь 6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдаж, өмнөх сараас 238 (5.2%)-аар нэмэгдсэн байна. Амаржсан эхчүүдийн 23 (0.4%) нь гэртээ төрсөн бөгөөд өмнөх сараас 6 (35.3%)-гаар нэмэгджээ.

Зураг 1. Амаржсан эх, төрсөн хүүхэд, сараар, 2020-2021 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Эрүүл мэндийн яамны “Төрөлтийн цахим бүртгэл”-ээр 2021 оны 5 дугаар сард 6124 эх амаржиж, 6199 хүүхдэд регистрийн дугаар олгожээ. Нийт төрсөн хүүхдийн 3207 нь эрэгтэй, 2992 нь эмэгтэй, 150 нь ихэр, хүүхдийн дундаж жин 3416 грамм, дундаж өндөр 50.8 см байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 5 сард 30.2 мянган хүүхэд төрсөн нь өмнөх оны мөн үеэс 1353 (4.3%)-аар буурсан байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 28.9 мянга (95.6%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан бөгөөд өмнөх оны мөн үеэс 1589 (5.2%)-өөр буурчээ. Нийт амьд төрөлтийн 249 (0.8%) нь төрөлхийн гажигтай, 1174 (3.9%) нь 2500 граммаас бага жинтэй байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 5 ногдож байна.

Харин 2021 оны 5 дугаар сард 6281 хүүхэд амьд төрсөн нь өмнөх сараас 74 (1.2%)-өөр нэмэгджээ. Нийт амьд төрсөн хүүхдийн 6050 (96.3%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан нь өмнөх сараас 258 (4.5%)-аар нэмэгдсэн байна. Нийт амьд төрөлтийн 53 (0.8%) нь төрөлхийн гажигтай байгаа нь өмнөх сараас 2 (3.6%)-оор буурч, 245 (3.9%) нь 2500 граммаас бага жинтэй байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 4 ногдож байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 5 сард нас баралтын 6656 тохиолдол бүртгэгдсэний 1999 (30.0%) нь эмнэлэгт, 4657 (70.0%) нь гэрийн (бусад газарт) нас баралт байна. Нийт нас баралт өмнөх оны мөн үеэс 102 (1.6%)-оор, эмнэлгийн нас баралт 126 (6.7%)-гаар нэмэгдэж, харин гэрийн (бусад газарт) нас баралт 24 (0.5%)-өөр буурчээ.

#### Хүснэгт 2. Нас баралт, эх, хүүхдийн эндэгдэл, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2021 I-V
	I-V	I-V	I-V	I-V	2020 I-V
Нас баралт	7 149	7 243	6 554	6 656	101.6
Эмнэлэгт нас баралт	2 015	2 131	1 873	1 999	106.7
Гэртээ (бусад газарт)	5 134	5 112	4 681	4 657	99.5
Эхийн эндэгдэл	11	7	13	13	100.0
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	541	527	459	383	83.4
Нялхсын эндэгдэл	447	443	380	327	86.1
Нярайн эндэгдэл	290	272	243	233	95.9
Эхийн эндэгдлийн харьцаа	35	22	41	43	-
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	17	16	15	13	-
Нялхсын эндэгдлийн түвшин	14	14	12	11	-
Нярайн эндэгдлийн түвшин	9	9	8	8	-

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Энэ оны 5 дугаар сард нас баралтын 1403 тохиолдол бүртгэгдсэний 519 (37.0%) нь эмнэлэгт, 884 (63.0%) нь гэрийн (бусад газарт) нас баралт байна. Нийт нас баралт өмнөх сараас 81 (5.5%)-ээр, гэрийн нас баралт (бусад газарт) 148 (14.3%)-аар буурч, харин эмнэлгийн нас баралт 67 (14.8%)-гоор нэмэгджээ.


Эхийн эндэгдэл 2021 оны эхний 5 сард 13 болж, өмнөх оны мөн үетэй адил байна. Эхийн эндэгдлийн харьцаа (100 000 амьд төрөлтөд ногдох) 43 болж, өмнөх оны мөн үеэс 2-оор нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 5 сард нийт нас баралтын 5.8 хувийг 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 85.4 хувийг нялхсын эндэгдэл, нялхсын эндэгдлийн 71.3 хувийг нярайн эндэгдэл эзэлж байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 383 болж, өмнөх оны мөн үеэс 76 (16.6)-гаар, нялхсын эндэгдэл 327 болж, 53 (13.9%)-аар, нярайн эндэгдэл 233 болж, 10 (4.1%)-аар тус тус буурсан байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 2021 оны эхний 5 сард 13 болж, өмнөх оны мөн үеэс 2-оор, нялхсын эндэгдлийн түвшин 11 болж, 1-ээр буурч, харин нярайн эндэгдлийн түвшин 8 болж, адил түвшинд байна.

Харин энэ оны 5 дугаар сард тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 12 болж, өмнөх сараас 3-аар, нялхсын эндэгдлийн түвшин 10 болж, 2-оор, нярайн эндэгдлийн түвшин 7 болж, 1-ээр тус тус буурсан байна.

Зураг 2. Хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох), сараар, 2020-2021 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2021 оны эхний 5 сард 57.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 43.2 мянга (4.0 дахин)-аар нэмэгдэхэд коронавирусын халдвараар өвчлөгчид 51.1 мянга (286.7 дахин)-аар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Хүснэгт 3. Халдварт өвчин, төрлөөр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

Үзүүлэлт	2018 I-V	2019 I-V	2020 I-V	2021 I-V	$\frac{2021 \text{ I-V}}{2020 \text{ I-V}}$
<b>Халдварт өвчнөөр өвчлөгчид</b>	<b>17 529</b>	<b>18 863</b>	<b>14 585</b>	<b>57 760</b>	<b>4.0<sup>1</sup></b>
Вирус хепатит	202	190	187	60	32.1
Сүрьеэ	1 642	1 688	1 588	983	61.9
Салхин цэцэг	3 839	5 593	1 675	122	7.3
Гар, хөл, амны өвчин	1 740	829	223	109	48.9
Цусан суулга	1 482	1 805	758	143	18.9
Тэмбүү	2 727	2 482	3 279	1 663	50.7
Гонококкт халдвар	2 131	2 329	2 417	1 388	57.4
Трихомониаз	1 917	1 818	2 184	1 214	55.6
ХДХВ/ДОХ	11	4	7	3	42.9
Мөөгөнцөр	723	659	1 540	581	37.7
Коронавируст халдвар	-	-	179	51 326	286.7 <sup>1</sup>

<sup>1</sup> Дахин

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл


Харин салхин цэцгээр өвчлөгчид 1553 (92.7%)-аар, цусан суулгаар өвчлөгчид 615 (81.1%)-аар, вирүст хепатитаар өвчлөгчид 127 (67.9%)-гоор, мөөгөнцрөөр өвчлөгчид 959 (62.3%)-өөр, тэмбүүгээр өвчлөгчид 1616 (49.3%)-гаар, гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчид 114 (51.1%)-өөр, трихомониазаар өвчлөгчид 970 (44.4%)-аар, гонококкт халдвар 1029 (42.6%)-аар, сүрьеэгээр өвчлөгчид 605 (38.1%)-аар буурчээ.

Энэ оны 5 дугаар сард нийт халдварт өвчний 30.6 мянган тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх сараас 14.7 мянга (92.8%)-аар нэмэгдэхэд коронавирусын халдвараар өвчлөгчид 14.6 мянга (99.3%)-аар, мөөгөнцрөөр өвчлөгчид 46 (90.2%)-гаар, вирүст хепатитаар өвчлөгчид 3 (50.0%)-аар, цусан суулгаар өвчлөгчид 3 (16.7%)-аар, тэмбүүгээр өвчлөгчид 49 (16.7%)-өөр, гонококкт халдвар 36 (15.1%)-гаар нэмэгдсэн нь нөлөөлжээ. Харин бусад өвчлөл 3-32 тохиолдол (1.5%-88.9%)-оор буурчээ.

Улсын хэмжээнд 2021 оны 5 дугаар сард ХДХВ/ДОХ-ын тохиолдол илрээгүй бөгөөд нийт бүртгэгдсэн тохиолдол 314 байна.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД


Зураг 3. Дэлхийн коронавирусын өвчлөл, нас баралтын тохиолдол, улс орноор, 2021 оны 5 дугаар сарын байдлаар



Дэлхийн хэмжээнд 2020 оны 1 дүгээр сараас 2021 оны 5 дугаар сард коронавирусын өвчлөлийн тохиолдол 223 улсад нийт 170.1 сая бүртгэгдэж, 3.7 сая хүн нас баржээ.

Коронавирусын өвчлөлийн тохиолдол 2021 оны 5 дугаар сард дэлхийн 183 улсад 20.2 сая бүртгэгдэж, өмнөх сараас 1.8 сая (8.1%) тохиолдлоор буурч, нас баралтын тохиолдол 387.6 мянга бүртгэгдэж, 14.8 мянга (4.0%)-аар нэмэгджээ.

Зураг 4. Дэлхийн хүн амын коронавирусын өвчлөл, нас баралтын тохиолдол, сараар, 2020-2021 он



Эх үүсвэр: ДЭМБ-ын мэдээлэл

Коронавирусын өвчлөлийн нийт тохиолдлыг дэлхийн улс орнуудын бүс нутгаар, 2021 оны 5 дугаар сарын байдлаар харвал Зүүн өмнөд Азийн бүс нутаг хамгийн их буюу 49.1 хувь, хамгийн бага нь Африкийн бүсийн орнууд 1.0 хувь эзэлж байна.


Харин коронавирусын нас баралтын нийт тохиолдлын 39.7 хувь нь Америкийн бүс нутгийн орнуудад, хамгийн бага нь Африкийн бүсийн орнуудад 1.2 хувь бүртгэгджээ.

### Коронавирус Монгол Улсад

Монгол Улсад коронавирусын халдварын тохиолдол бүртгэгдсэнээс хойш 2021 оны 5 дугаар сарын байдлаар нийт 52.5 мянган тохиолдол бүртгэгдсэний 26.5 мянга (50.4%) нь эдгэрсэн байна. Нийт тохиолдлын 509 (1.0%) нь зөөвөрлөгдсөн, 52.0 мянга (99.0%) нь дотоодод тархсан халдвар байна.

Улсын хэмжээнд коронавирусын 10000 хүнд ногдох өвчлөлийн түвшин 154, нас баралтын түвшин 1 байна. Өвчлөлийн тохиолдол Өмнөговьос бусад аймаг, нийслэлд бүртгэгдсэн байна.


Зураг 5. Коронавирусын халдвараар өвчлөгчид, нас баралт, аймаг, нийслэлээр, 2021 оны 5 дугаар сарын байдлаар




Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Коронавирусын нас баралтын нийт тохиолдол 2021 оны 5 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 288 бүртгэгдсэний 281 нь Улаанбаатар хотод, Булганд 3, Завханд 2, Сүхбаатар, Орхон аймагт тус бүр 1 тохиолдол байна.

Зураг 6. Коронавирусын халдвараар өвчлөгчид (10000 хүнд ногдох), бүсээр, 2021 оны 4 дүгээр сар




Зураг 7. Коронавирусын халдвараар өвчлөгчид (10000 хүнд ногдох), бүсээр, 2021 оны 5 дугаар сар



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Коронавирусын өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшин 2021 оны 5 дугаар сард, өмнөх сартай харьцуулбал улсын хэмжээнд 86 болж, 2.0 дахин, Улаанбаатар хотод 169 болж, 2.3 дахин нэмэгдэж, харин төвийн бүсэд 11 болж, 15-аар, зүүн бүсэд 7 болж, 4-өөр, хангайн бүсэд 11 болж, 3-аар, баруун бүсэд 13 болж, 1-ээр тус тус буурчээ.

Зураг 8. Коронавирусын өвчлөл, нас баралтын тохиолдол, сараар, 2020-2021 он




Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Харин энэ оны 5 дугаар сард коронавирусын 23 зөөвөрлөгдсөн, 29.3 мянган дотоодод тархсан халдвар, нийт 29.4 мянган тохиолдол илэрсэн нь өмнөх сараас 14.6 мянга (2.0 дахин)-аар нэмэгджээ.

Нас баралтын 161 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх сараас 42 (35.3)-оор нэмэгджээ.


Зураг 9. Коронавирусын тохиолдлын тоо, насны бүлэг, хүйсээр, 2021 оны 5 дугаар сар



Коронавирусын нийт тохиолдлын 13.2 мянга (45.1%) нь эрэгтэй, 16.1 мянга (54.9%) нь эмэгтэй байна. Насны бүлгээр харвал 20-44 насныхан 14.9 мянга (50.9%), 45-аас дээш насныхан 8.0 мянга (27.4%), 0-19 насныхан 6.4 мянга (21.8%) байна.

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Зураг 10. Коронавирусын вакцины хамралт, тун, хамрагдвал зохих хүн амд эзлэх хувиар, аймаг, нийслэлээр, 2021 оны 5 дугаар сарын байдлаар



Эх үүсвэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв

Улсын хэмжээнд 2021 оны 5 дугаар сарын байдлаар коронавирусын халдвараас сэргийлэх вакцинжуулалтын 1 дүгээр тунд 1.8 сая буюу хамрагдвал зохих хүн амын 89.1 хувь, 2 дугаар тунд 1.3 сая буюу хамрагдвал зохих хүн амын 62.8 хувь нь хамрагджээ. Өмнөговь аймагт 1 дүгээр тунгийн хамралт 100 хувь болсон байна. Улаанбаатар хотод 2 дугаар тунгийн хамралтын хувь 77.3 хувь болж, улсын дунджаас 14.5 пунктээр их байна. Увс аймагт 1 дүгээр, Баян-Өлгийд 2 дугаар тунгийн хамралтын хувь хамгийн бага байна.

### **АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР:**

**Нярайн эндэгдлийн түвшин** (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Нялхсын эндэгдлийн түвшин** (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин** (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Эхийн эндэгдлийн харьцаа** (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Амьд төрөлт:** Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар үргийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

**Амьгүй төрөлт:** Жирэмсний 22 долоо хоног ба түүнээс хойших хугацаанд, 500 граммаас дээш жинтэй төрсөн нярайд амьдын шинж тэмдгийн аль нь ч (зүрхний цохилт, судасны лугшилт, булчингийн хөдөлгөөн) илрэхгүй байгааг хэлнэ.

**Эндсэн эх:** Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

**Амьгүй төрөлтийн түвшин** (1000 нийт төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд нийт төрсөн хүүхдийн тоог амьгүй төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Эх үүсвэр:** Эрүүл мэндийн яамны сарын мэдээ

**Ангилал, код:** Өвчний олон улсын ангилал /ICD-10/.

**Мэдээлэл авах линкүүд:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:** 2021 оны 7 дугаар сарын 19



*Хүн ам, нийгмийн статистикийн  
газрын дарга А.Амарбал  
Утас : (976-51)-264805*

*Хүн ам, нийгмийн статистикийн газрын  
статистикч Г.Урангоо  
Утас : (976-51)-263966*